



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/89

Улаанбаатар хот

Томилолтоор ажиллах тухай


Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 117 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх” журам, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийх ажлын удирдамжийг нэгдүгээр, шалгалт тохируулга хийгдэх эрүүл мэндийн байгууллагын жагсаалтыг хоёрдугаар, томилолтын зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Томилолтоор ажиллах мэргэжилтнүүдийн зардлыг төсвийн зохих зардлаас тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.


3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргаа, санхүү үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба /Д.Тамир/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын баг /Ч.Баттулга/-т тус тус даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА

420372



## ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ШАЛГАЛТ ТОХИРУУЛГА ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

**Зорилго:** Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 117 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 249 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт “Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх” журмын хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа өвчтөний хяналтын монитор, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, дефибриллятор болон цахилгаан мэс заслын аппаратад олон улсын жишигт нийцсэн симулятор, анализатораар стандартын дагуу шалгалт тохируулга хийж, улмаар тухайн эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны үнэн, зөв байдлыг үнэлэх, шаардлага хангахгүй байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийг хэвийн найдвартай ажиллагааг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллах;

**Хамрагдах байгууллага:** Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа Налайх дүүргийн эрүүл мэндийн төв, Багануур дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл;

**Хийгдэх хугацаа:** 2017.06.26 – 2017.06.28-ны өдрүүдэд;

**Гүйцэтгэгч байгууллага:** Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба;


### Үйл ажиллагаа:

- Эрүүл мэндийн байгууллага дээр очиж, шалгалт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэнэ.
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.
- Шалгалт тохируулгын үр дүнг тайлагнан гэрчилгээ болон мэдэгдэл олгоно.
- Шалгалт тохируулгын үр дүнг нэгтгэн ЭМЯ, МХЕГ-т хүргүүлнэ.

### Үр дүн:

- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагаа хангагдана.
- Олон улсын стандартад нийцсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа ашиглана.
- Шаардлага хангахгүй эмнэлгийн тоног төхөөрөмжийг тодорхойлно.


Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий  
захирлын 2017 оны 06 сарын 02 ны  
өдрийн А/59 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХАРЪЯА  
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Дефибриллятор	Зурхний цахилгаан бичлэгийн аппарат	Цахилгаан мэс заслын аппарат	Өвчтөний хяналтын монитор	Хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч	Нийт	Ажиллах хүн	Нийт ажиллах өдөр	Шалгалт тохируулга хийх огноо
1	Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв	1	2	2	5	5	15	4	1	2017.05.30
2	Багануур дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл	4	7	2	16	13	42	4	2	2017.05.31
НИЙТ		5	9	4	21	18	57	4	3	

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий  
захирлын 2017 оны 02 сарын 02 ны өдрийн  
А/89 дугаар тушаалын гуравдугаар хэвсрэлт



## ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

1. Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв болон Багануур дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлд ажиллах томилолтын төсөв

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бензин	100км/17л	51	1,660.0	84,660.0
2	Байр	хоног	2*5	40,000.0	400,000.0
3	Хоол	хоног	3*5	29,000.0	435,000.0
<b>Нийт дүн</b>					<b>919,660.0</b>

\* нэг талдаа 150 км

\* жолоочийн томилолтыг оруулан тооцов.